


БАТЛАВ.

“ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ”  
ЗАХИРАЛ  
Ч.БАТ-ЭРДЭНЭ



БАТЛАВ.

“МИЧЕЛ АМАЗОНКА” ХХК-НЫ  
ЗАХИРАЛ  
Ч.МӨНХЖАРГАЛ



## АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2016 он ..... сарын ....-ний өдөр

№

20160902038

Улаанбаатар хот

Нэг талаас “Эрүүл мэндийн хөгжлийн төв” /Сүхбаатар дүүрэг, энхтайвны гудамж 1-р хороо, 136 хаягт байрлах/ түүнийг төлөөлөн захирал Ч.Бат-Эрдэнэ (цаашид захиалагч), нөгөө талаас “Мичел амазонка” ХХК-ны Сүхбаатар дүүрэг, 4 дүгээр хороо, 22-19 тоот хаягт байрших/, захирал Ч.Мөнхжаргал (цаашид гүйцэтгэгч) нар (хамтад нь “талууд” гэх) Монгол Улсын Иргэний хуулийг удирдлага болгон дараах гэрээг харилцан тохиролцож байгуулав.

### 1. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэ гэрээгээр Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулагдах Эрдэм шинжилгээний хурал, хүндэтгэлийн хуралд зориулан Гүйцэтгэгч тал нь захиалагчийн бэлтгэн өгсөн лого, загварын дагуу даавуун материалаар шаардлага хангасан тор бэлтгэн нийлүүлнэ.
- 1.2. Захиалагч нь гүйцэтгэсэн ажлыг хүлээн авч, хөлсийг гэрээгээр тохиролцсон хэлбэр хугацаанд төлнө.

### 2. Талуудын эрх үүрэг

- 2.1. Захиалагч тал Гүйцэтгэгч талыг үүргээ биелүүлэхэд шаардагдах лого загвар, тоо хэмжээг өгөх;
- 2.2. Гүйцэтгэгч тал чанар, ажлын шаардлагад нийцсэн тор бэлтгэн нийлүүлэх;
- 2.3. Захиалагч тал гүйцэтгэсэн ажлын цаг хугацаа, үр дүнг харгалзан төлбөрийг төлөх;
- 2.4. Гүйцэтгэгч нь ажлыг биечлэн гүйцэтгэнэ.

### 3. Гүйцэтгэх хугацаа

- 3.1. Гэрээнд өөрөөр заагаагүй бол ажил гүйцэтгэлийн хугацааг урьдчилан тохиролцсоны дагуу гүйцэтгэнэ.
- 3.2. Гүйцэтгэгч тал ажлыг заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүрвэл энэ тухайгаа Захиалагчид нэн даруй мэдэгдэнэ.
- 3.3. Ажил гүйцэтгэх ерөнхий хугацаа: 2016 оны 9 сарын 10 ний өдрийг хүртэлх

### 4. Үнэлгээ ба Төлбөр

- 4.1. Нэхэмжилж буй төлбөр нь зөвхөн талуудын тохирсон үйлчилгээнд хамаарна.
- 4.2. Гэрээгээр гүйцэтгэх ажлын нэг бүрийн 5000 төгрөгөөр 300 ширхэг цүнхийг бэлтгэх бөгөөд нийт хөлс 1.500.000 /нэг сая таван зуун мянган/ төгрөг, үүнд НӨАТ-ын 10% орсон болно.

4.3. Урьдчилгаа төлбөрийн 50% буюу 750.000 /долоон зуун тавин мянга/ төгрөгийг нэхэмжлэл хүлээн авсан өдрөөс хойш ажлын 3 хоногт, үлдэгдэл 50% буюу 750000 /долоон зуун тавин мянга/ төгрөгийг гэрээ дүгнэсэн актыг үндэслэн гүйцэтгэгч талын нэхэмжлэлээр ажлын 3 хоногт багтаж шилжүүлнэ.

4.4. Гэрээгээр гүйцэтгэсэн ажлын хөлсийг “Мичел амазонка” ХХК-ны Хас банкны 5001258849 тоот дансанд шилжүүлнэ.

### 5. Үүрэг, хариуцлага

5.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлнө.

### 6. Гэрээ дуусгавар болох, цуцлах

6.1. Гэрээг дараах үндэслэлээр дуусгавар болгоно.

6.1.1. Гэрээний хугацаа дууссан

6.1.2. Талууд харилцан тохиролцсон

6.2. Захиалагч тал эсвэл Гүйцэтгэгч тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.

### 7. Бусад заалт

7.1. Гэрээг гурван хувь байгуулж, хоёр талын гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

7.2. Гэрээний хугацаа, нөхцөл байдлын талаар өөрчлөлт оруулахаар бол хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

7.3. Хэрэв талуудын хооронд маргаан гарвал талууд үл маргах журмаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрэж чадахгүйд хүрвэл Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

7.4. Ажил гүйцэтгэх явцад гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж, талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.


### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

ЗАХИРГАА АЖ АХУЙН АЛБАНЫ ДАРГА

Л.ОЮУНЧИМЭГ



Утас:976-70128806

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“МИЧЕЛАМАЗОНКА” ХХК

ЗАХИРАЛ

Ч.МӨНХЖАРГАЛ



  
Утас:976-99013856